Буцаж орж ирэх зөвшөөрөл чөлөөлөхий г түдгэлзүүлэх болон урт хугацааны визтэй иргэд буцаж орж ирэхэд шинжилгээний бичиг өгөхтэй холбоотой мэдээлэл

А. Буцаж орж ирэх зөвшөөрөл чөлөөлөхий г түдгэлзүүлэх болон буцаж орж ирэх зөвшөөрөл хүсэхтэй холбоотой мэдээлэл

- 2020оны 6сарын 1ний өдрөөс эхлэн буцсаны дараа Солонгост буцаж орж ирэх гэж бай гаа бүрттгэлтэй гадаа д иргэн「Цагаачлалын хяналтын тухай хууль」 30-р заалтын дагуу буцаж орж ирэх зөвшөөрөл авах хэрэгтэй бөгөөд буцаж орж ирэх зөвшөөрөл авахгүй гарсан тохиолдолд гадаад иргэний үнэмлэх хүчингүй болно.
- Харин, Дипломат албан хаагч (A-1), төрий н албан хаагч (A-2), Тохиролцоо (A-3) болон Гадаадын харьяат Солонгос үндэстэн (F-4) тус тус ангилалтай тохиолдолд буцаж орж ирэх зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд, өмнөхтэй адил буцаж орж ирэхэд болно.
- Буцаж орж ирэх зөвшөөрлий г улсын хэмжээнд бүх гадаад иргэдий н харьяатын албанд хүсэлт гаргах боломжтой. (Нисэх буудал дээр ч гэсэн мэдэгдэх боломжтой)

Б. Буцаж орж ирэх урт хугацааны оршин суугч шинжилгээний бичиг өгөх тухай

- 2020оны 6сарын 1ний өдрөөс эхлэн буцсаны дараа Солонгост эргэж орж ирэх бүрттгэлтэй гадаад иргэд (Дипломат албан хаагч (A-1), Төрий н албан хаагч (A-2), Тохиролцоо (A-3), Гадаадын харьяат Солонгос үндэстэн (F-4) виз ангилал

хамрагдахгүй) байгаа газрынхаа буцах өдрөөс эхлэн 48цагийн доторх корона 19 шинжилгээ өгөн шинжилгээний хариу бичгийг биедээ авч орж ирнэ.

<Шинжилгээний бичигтэй холбоотой анхаарах зүйлс >

▪Шинжилгээний бичгийг байгаа газрынхаа хүчинтэй эрүүл мэндийн байгууллагаас авах бөгөөд, англи хэл дээрх бичиг ийг хүлээн зөвшөөрөгдөнө.

▪Шинжилгээний бичиг дээр халуурах, ханиалгах, толгой өвдөх, амьсгалахад хэцүү, булчингийн өвдөлт, хатгалгаа зэрэг шинж тэмдэг байгаа эсэх болон шинжилгээ хийлгэсэн өдөр (Ирэх өдрийн өмнө 48цагийн доторх щингжилгээг л хүлээн зөвшөөрнө), Шинжилгээг авсан хүн заавал бичигдсэн байна.

▪Шинжилгээний бичигт COVID 19 сөрөг(Test Negative) эсэх нь заавал тусгагдах шаардлагагүй .

Харин, сөрөг эсэх нь тусгагдсан тохиолдолд хүчинтэй шинжилгээний бичигт тооцно.

- Шинжилгээ өгөөгүй болон хүчинтэй шинжилгээний бичиг байхгүй тохиолдолд, хуурамч· өөрчилсөн бичиг болон худал хуурмаг бичиг өгсөн тохиолдолд онгоцонд суух болон орж ирэхийг татгалзах зэрэг эрсдэлийг хүлээх болно.
- Эсвэл, <u>гадаад дахь дипломат төлөөлөгчийн газраас авсан хүчинтэй ‘Тусгаарлахыг чөлөөлсөн бичиг’ийг биедээ авч яваа хүн шинжилгээний бичиг өгөөгүй ч гэсэн тусгай лан буцаж орж ирэх боломжтой .</u>